

ЭРТНИЙ МОНГОЛЧУУДЫН ЗУРАГ ДҮРСЛЭЛД ЭВЭРТ АМЬТНЫ ДҮРИЙГ ШҮТЛЭГ БИШРЭЛТЭЙ ХОЛБОН ҮЗЭХ НЬ

П. Алтанцэцэг *

Түлхүүр үг: Хадан зураг, буган хөшөө, тэнгэр шүтлэг, малгай, үлгэрийн амьтан, бэлгэт гөрөөс

Эртний Монголчуудын шүтлэг, сэтгэлгээний гол ухагдахуун нь “Тэнгэр” хэмээх ойлголт бөгөөд бусад ард түмний сэтгэлгээнд мөн үүнтэй төстэй ухагдахуун уламжлагдаж иржээ. Нүүдэлчдийн шүтлэг бишрэлд дээд Тэнгэр, доод Газар хоёр нь нэгдмэл ертөнцийн эр эм эхлэл, эсрэг тэсрэг чанар гэж үзэх нь байгалийн зүй тогтлыг бодит дүрээр ойлгох сэтгэлгээний хамгийн энгийн хувилбар мэт боловч угтаа сав шим ертөнцийн зүй тогтол, сэтгэл оюуны нэгдмэл чанарыг илтгэсэн маш хийсвэр утгатай гүнзгий ойлголт юм. Тэнгэр хэмээх энэхүү хийсвэр дүрслэл нь бүхний оршихуй, шүтэн барилдлагын мөн чанарыг илэрхийлж, нүүдэлчдийн соёлын тулгуур нийтлэг ойлголт болон тогтсоныг өвөг дээдсийн соёлын өв бидэнд нотлон харуулж байдаг.


Эртний хүмүүс үхэж төрөх жам ёс, байгаль ертөнцийн аливаа үзэгдлийг эзэн савдагт хамаатуулж, тэр эзэн савдаг нь нар сарны мандах жаргах, хур бороо орох эсэхийг захиран мэддэг гэж итгэдэг тул тэднийг шүтээн болгон тахиж, дөрвөн улирлын туршид мал ахуй өсөн үржиж, өгөөж шим нь арвин, гэнэтийн аюул гамшиг тохиохгүй, энх амгалан байхын сайн сайхан хүсэл мөрөөдлөө даатган сүсэглэдэг байв. Энэ нь “Тэдний ухамсарт онохуун оногдохуун, бодит үзэгдэл болон түүний санаа, тэмдэг тэмдэглэгдэхүүний харьцаа холбоог ялган салгах бус, харин нэгдмэл тогтолцоонд авч үздэг төсөөллийн хэлбэр байсан” гэж Оросын эрдэмтэн С.М.Мелетенский онцолсон (С.Дулам, 1989, 9) бол доктор С.Батчулуун “Балар эртний зураг дүрслэлд юмс үзэгдлийн үүсэл гарвацийг мөн чанар нь хэмээн ухамсарлаж, мэдрэхүйд буух хоёрдогч шинжээр нь бодит байдлыг орлуулсан дүрслэл элбэг байдаг” (С.Батчулуун, 2009, 38-44) тухай судалгаандаа онцолсон буй. Байгалийн аливаа үзэгдлийг зүгээр нэг эзэн савдгаар төлөөлөн бодох биш, тэдгээрийг хооронд нь зохих үйл хөдөлгөөн, шинж дүрээр амьджуулан, үзэгдэл болон санааг үйл-шинжээр холбосон эртний хүмүүсийн зураг дүрслэл нь дүрийн нөлөөлөх хүчний талаарх тэдний төсөөлөлтэй нягт холбоотой байжээ. “Аливаа зүйлийг зурж дүрслээд түүнийгээ тахиx, эсвэл ямар нэг хүчирхэг амьтныг овог аймгийнхаа сүлд, сахиус болгоод өөрсдөө түүнийхээ дүр байдалд орж, үйл хөдлөлийг нь дууриан аяглах зэрэг нь нэгэн төрлийн зөгнөл, домын шинжтэй зан

* Монгол Улсын Боловсролын Их Сургууль

үйл бөгөөд энэ нь тэдгээр дүрийн нөлөөлөх хүчин зүйл” (Э.Х.Гомбрих, 2010, 42-43)-ийн ач холбогдлыг өндөрт үзэж байсныг илтгэнэ. Өгүүлэн буй дүрийн нөлөөлөх хүчин зүйл бол яахын аргагүй балар эртний хүний амьдралын орчин нөхцөл, ертөнцийг үзэх үзлээс үүдэн буй болсон хийсвэр сэтгэлгээний тусгал бөгөөд хожим үеэс үед уламжлан боловсорсоор дохио тэмдэг, хээ угалзын тогтолцоот урлагийн өвөрмөц хэв шинж бүрэлдэхийн үндэс суурь болсон нь гарцаагүй.

Хадан зургийн дурсгалд буга, аргаль, янгир, үхэр зэрэг эвэрт амьтны дүрслэл тун элбэг тохиолддог. Судлаачид үүнийг эртний хүмүүс аливаа амьтныг дүрслэхдээ бусдаас ялгарах онцлог шинжээр нь буюу эвэр, дэл, сүүл, хоншоор зэргийг илүү тодотгодог байсан нь хийсвэр сэтгэлгээний илрэл гэж тайлбарладаг. Тэгвэл дээр өгүүлсэн дүрийн нөлөөлөх хүчин зүйлийг үндэс болгон үзвэл, тэдгээр амьтныг дүрсэлсэн нь зөвхөн гадаад дүрийн өвөрмөц содон байдлаас гадна, эвэрт онцгой ач холбогдол өгч, түүний ид чадалд сүсэглэж байснаас үүдэлтэй гэж үзүүштэй.

Хадан зурагт үлдсэн эвэрт амьтдын дүрслэл дотор үнэхээр эх газрын бус гэмээр өвөрмөц сонин амьтад цөөнгүй тааралддаг. Тухайлбал, “Гүрвэл маягийн толгойтой, том бөөрөнхий цэлгэр нүдтэй, загас шиг иржгэр шүдтэй, могой шиг хэлтэй, хойд хоёр мөчдөө сарьслаг сарвуутай, эвэрт амьтны дүрслэл” (Г.Гонгоржав, 2005, 104) байдаг. Урд хоёр мөчөөрөө барьсан буга нь түүний идэш эсэх нь мэдэхгүй ч энэ амьтан үнэхээр үлэмж биетэй нь ойлгогдоно. Ийм үлэмж биетэй, үлгэрийн мэт сонин дүрс байдалтайгаас нь харахад газрын амьтан биш бололтой.



Зураг 1. Баян-Өлгий аймгийн Цагаан салаагийн хадны зураг. Шинэ чулуун зэвсгийн үе

Түүнчлэн “Эрт урьд цагт тэмээ олон салаа сүрлэг сайхан эвэртэй байжээ...” гэдэг шиг буга мэт олон салаа эвэртэй хэрнээ нуруу сэрвээндээ тэмээний бөх мэт хоёр овгортой, хоншоор нь буга, тэмээний аль нь ч байж болмоор өвөрмөц дүрслэл ч бий. “Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Бичигтийн ам, Ховд аймгийн Алтай сумын нутаг Уушигийн цохион, Архангай аймгийн Их Тамир сумын нутаг Хөрөөгийн үзүүр, Чулуут голын адаг зэрэг газар, мөн хилийн чанадад ч хадан дээр сийлсэн буга адил олон салаа эвэртэй хоёр бөхт тэмээний дүрслэл олдсон” (Г.Гонгоржав, 2005, 95-96) тухай судлаачид өгүүлж буй. Энд өгүүлж буй амьтны дүрслэл нь эвэртэй тэмээ, бөхтэй буга, эсвэл бүр сэрвээг нь багахан хэтрүүлж дүрсэлсэн энгийн буга аль нь ч байлаа гэсэн дүрслэлийн хувьд нэлээд эргэлзээ төрүүлэхүйц өвөрмөц байгаа юм. Хүрэл, төмөр зэвсгийн үед хамаарах буга, тэмээний холимог дүрслэл бүхий энэ дүрийг



Зураг 2. Баянхонгор аймгийн Баянлиг сум.

Бичигтийн хадны зураг. Хүрэл, төмөр зэвсгийн үе

Зураг 3. Увс аймгийн сагил сум. Төмөр цоргын хадны зураг. Хүрэл, төмөр зэвсгийн үе

хийсвэр сэтгэлгээний дүрслэл, үлгэр домгийн амьтан гэж үзвэл, түүнийг авлаж, эрхэндээ оруулж буй мэтээр дүрсэлсэн нь тэнгэрийн, далдын хүч чадал, эрхшээл, хишгийг хүртэхийн дом бэлгэ, саахь дүрийн нөлөөлөх хүчин зүйлийг чухалчилсан сүсэг бишрэлийн агуулга бүхий зураг дүрслэл болно.

Мөн далавчтай бугын дүрслэл сонирхол татаж байна. Энэ буга нь төв Азийн нутаг дахь эртний булшнаас цөөнгүй олддог бэлгэт гөрөөс гэх янгир мэт ганц эвэртэй, далавчтай, дөрвөн хөлөө нугалан нисч буй байдалтай буга мэт амьтны дүрслэлтэй нэлээд төстэй байна. Бэлгэт гөрөөсийг ихэнх тохиолдолд зэгзгэр гоолиг биетэй, “Үүл гишгэлэн яваагаар дүрсэлсэн нь түүнийг газрын бус тэнгэрийн амьтан гэсэн санааг илтгэсэн” (Ч.Ерөөл-Эрдэнэ, 2015, 82) байдаг.



Зураг 4. Дундговь аймгийн Дэл уулын хадны зураг

Зураг 5. Хүннүгийн язгууртны оршуулганаас олдсон далавчтай бэлгэт гөрөөсний дүрслэл бүхий хөмөлдөргөний чимэглэл

Зураг 6. Хүннүгийн язгууртны оршуулганаас олдсон үүлэн дундах бэлгэт гөрөөсний дүрслэл бүхийн хударганы чимэглэл

Археологич Ч.Ерөөл-Эрдэнэ бэлгэт гөрөөсний талаар нилээд баримт цуглуулж, “Бэлгэт гөрөөс нь хүний хэлээр ярьж, тэнгэр газрын хооронд хэл болдог” (Ч.Ерөөл-Эрдэнэ, 2015, 86-87) гэхчилэн тодорхой зураглал гаргасан байна.

Хүннүгийн булшнаас бэлгэт гөрөөснөөс гадна сарлаг, буга, янгир, луун дүрст чимэглэлүүд олдсон байдаг бөгөөд эдгээр нь бүгд эвэртэй байгаа нь эврийг дээд тэнгэртэй холбогдох ид чадалтай зүйл гэж ухамсарлаж, өөд бологсдынхоо сүнсийг тэнгэрийн оронд одуулахдаа эвэрт амьтдаар замчлуулсны тэмдэг бололтой. Эдгээрийн доторх сарлаг мэт үслэг амьтныг судлаачид сарлаг, эсвэл сарлаг толгойтой, ямаан биетэй зөн билгийн амьтан гэж тайлбарлаж байна.

Зураг 7. Хүннүгийн булшнаас олдсон эвэрт амьтны дүрслэл бүхий хөмөлдөргө, хударганы



чимэглэлүүд

Буган хөшөөнд бугыг дээш тэмүүлж буй, хөшөөг бүхэлд нь ороосон, доош чиглэсэн байдалтай гурван янзаар дүрсэлсэн байдгийг судлаачид тухайн буган хөшөөний эзний сүнс очих газрыг үзүүлсэн гэж таамагладаг. Тухайлбал, “Дээш тэмүүлж буй буган дүрслэл нь өөд болоочийн сүнсийг тэнгэр рүү авч явж байгаа, буган хөшөөг тойрон ороосон дүрслэл нь түүний сүнс хүний орчлонд эргэн төрнө гэсэн санааг, доош чиглэсэн бугын дүрслэл нь нас барагчийн сүнсийг дээш дэгдээхгүй эх дэлхийн гүн рүү шингээж байгаа гэсэн байдлаар дүрсэлсэн байж болох юм” (Ж.Гантулга нар, 2016, 25).

БНХАУ-ын Хөлөнбуйраар нутагтай Орчоон¹ үндэстний “Нарны охин” хэмээх домогт “... Их Хянганы нурууны Байгаль уулын бэлд нэгэн нуур байх бөгөөд тэр нууранд тэнгэрийн долоон охин ирж биеэ угаадаг гэнэ. Тэдний хамгийн бага нь Нарны охин. Нэгэн өдөр биеэ угаахаар нууранд ирээд анчин залуутай учирч, хайр сэтгэлтэй бололцоод, хүү төрүүлжээ. Он цаг өнгөрч, нарны охин тэнгэрийн орондоо хариад, хүний орчлонд эргээж ирж чадахгүй болсонд нөхөр хүү хоёр нь цаа бугын эвэр дээр суун тэнгэрийн оронд очоод, хамтдаа элэг бүтэн сайхан амьдарсан” (E Xiao Nan, 2011, 115) тухай гардаг нь эгээ л буган чулуун дээрх өөд болоочийн сүнсийг тэнгэрийн орон луу авч явдаг бугатай адил байна. Мөн нутгийн ОлгуяаЭвэнк² ардын дунд нэгэн уламжлалт зан үйл байдаг нь “Бага хүүхэд айж цочиж, өвдсөн үед бөө залж, Умай (Нялх хүүхдийг хамгаалдаг бурхан) сахиусыг тахидаг гэнэ. Энэ нь чухамдаа тэнгэр, газрыг тахиx зан үйл юм. Ингэхдээ хар, цагаан хоёр зүсмийн цаа буга барьж бэлтгээд, хар бугаар газрыг, цагаан бугаар тэнгэрийг тахина” (Wang Li Zhen, 2006, 241). Энэ нь Умай сахиус хар буга хөллөн ирж, хүүхдийн сүнсийг авч явахаар эрж хайдаг ба харин цагаан буга болвоос тэнгэрт хүрэх увидас чадалтай гэж үздэгээс үүдэлтэй аж. Хар, цагаан хоёр зүсмийн буга нь бөөгийн шашины цагааны тэнгэр, харын тэнгэрийг зааж буй.

Эндээс үзэхэд нүүдэлчид хүн нас барсны дараа сүнс нь өөр ертөнцөд очдог эсвэл эргэн төрдөг гэдэгт итгэж, түүнтэй холбогдох элдэв зөн билгийн зан үйл хийдэг байсан нь илт байна. Буган чулуун хөшөөнд дүрслэгдсэн дээш тэнгэрт дүүлж, доош газар луу шумбаж буй бугын дүрслэл нь цаатан ардын үлгэр домог, зан үйлийн зүйлд байх тэнгэр газрыг нэвтрэн туулах чадалтай хар, цагаан цаа бугын дүртэй утга бэлгэдлийн хувьд ижил байгаа нь нүүдэлчдийн өвөг дээдсийн ухамсарт дээд, доод ертөнцийн тухай ойлголт нийтлэг оршиж байсныг илтгэнэ.

Якут Эвенк бөөгийн хувцас нь малгай, хүрэм, банзал, алчуур гэсэн дөрвөн хэсгээс бүрдэх ба хэсэг бүрийг бугын арьсаар хийж, цутгамал болон ялтсан төмрөөр бугын үе гишүү, ясны бүтцийг дууриалган хийж чимдэг. Малгай дээр төмрөөр цутгаж хийсэн бугын эврийг тогтоож, банзлын зүүн, баруун хоёр талд төмөр гинж унжуулж, бугын хойт хөлийг төлөөлүүлдэг. Ийнхүү бөөгийн хувцасны бүтэц байдал, хэлбэр маяг нь бүхэлдээ бугыг дүрслэх ба тэдний өвөг дээдэс буга ба буган онгод хөллөсөн бөө онгод шүтээдтэй холбогдож чадна гэдэгт итгэж байсныг давхар гэрчилдэг.



Зураг 8. Хамниган бөөгийн малгай

¹Орчоончууд нь Өвөр Монголын Хөлөнбуйр аймгийн Орчоон хошуу, Хармөрөн мужийн НаХөсянь зэрэг газраар тархан суусан цөөн тоот үндэстэн. Орчоон хэл нь Алтай язгуурын Манж - Тунгус хэлтний бүлэгт багтдаг.

² Алтай язгуурын Манж - Тунгус хэлтний бүлэгт багтах Эвенк үндэстэн нь БНХАУ-ын ӨМӨЗО, Хармөрөн муж, Шинжян Уйгурын ӨЗО, ОХУ-ын Сибирь, Монгол зэрэг газраар тархсан байдаг. Үүнээс ӨМӨЗО-ы Хөлөнбуйр аймагт Эвенк үндэстний өөртөө засах хошуу, Хуучин Барга хошуу зэрэг газраар тархан суурьшсан Эвенк үндэстнүүд нь өөр хоорондоо удам угсаа, хэл аялга, эрхэлж ирсэн аж ахуй, зан үйл, хувцас заслаараа багахан ялгаатай Якут, Тунгус, Солон гурван ястнаас бүрддэг. Үүнээс Якут Эвенкчүүдийг Буга тэжээгч аймаг, Тунгус Эвенкчүүдийг Хамниган Эвенк гэж нэрлэдэг.

Энэ мэт эвэрт малгайн тухай жишээ баримт тун элбэг. “Хойд Хангийн үеэс (951-979 он) Юань гүрний үе (1271-1368 он) хүртэл хууль баригч болон хянагч зэрэг өндөр тушаалын түшмэд чигч, шударгын бэлгэдэл болгон “Толч гөрөөст малгай” гэх малгайг өмсөж байсан” (Ерөөл-Эрдэнэ, 2015, 87), “Хан улс (202-220 он) - ын үед умардын зарим үндэстний эмэгтэйчүүд үхрийн эврийг дууриалгаж сийлсэн алтадсан модон толгойн гоёл зүүдэг байжээ. Түүнээс хойш Хан улсын умард бие дэхь улсуудад хуримласан эмэгтэй эгч дүүгүй бол толгойдоо ганц эвэр, эгч дүүтэй бол даруй тэдэн эвэр зүүдэг байжээ. Үүнээс гадна Хүннүд цагаан Хүннү гэх нэгэн бүлэг байж, тэд толгойдоо 5 тохой өндөр эвэрний хэв маягийг дууриалган хийж, 3 тохой хэсэгт нь шүр шигтгэж суулгадаг байсан” (МартаБояр, 1994, 102-104) тухай гадна дотны судлаачид бичсэн буй. Одоо ч зээрийн толгойн арьс, эврээр малгай хийж өмсөх уламжлал Орчоон түмний дунд хадгалагдсаар буй.



Зураг 9. Орчоон үндэстний малгай

Амьтны эврээр тэргүүнээ гоёх, эвэрт малгай өмсөх зэрэг нь бүр эрт буюу хүрэл, төмрийн үе, түүнээс ч эрт үеэс уламжлалтай болох нь мөн л шүтлэг бишрэл, оршуулгын холбогдолтой хадан зургуудаар батлагдаж байна. Шүтлэгийн бишрэлийн сэдэвт хадны зурагт эртний хүмүүсийн орчлон ертөнц, байгалийн үзэгдлийн мөн чанарыг ухамсарлах ойлголтоос үүдэлтэй тэнгэр, нар, сар, од эрхэсийг шүтэж тахьсан, тэдгээрийн сүр хүчинд шүтсэн зураг дүрслэл элбэг байдгийн дотор толгойдоо эвэртэй, үхэр толгойтой хүний дүрслэл мөн л цөөн боловч тохиолддог. Үүнд, Хятадын судлаачдын бөө гэж үзсэн ЮньНань, Өвөр Монголын нутгаас олдсон хуучин чулуун зэвсгийн үед хамаарах хадан зургууд, манай Говь-Алтай, Өмнөговь аймгуудаас олдсон үхэр толгойтой хүний дүрслэл бүхий хадан зургуудыг өгүүлж болно. Эрт үед овог аймгийн ахлагч нь аж ахуйн ажиллагааг удирдан явуулахаас гадна, шүтлэг мөргөлийн зан үйлийг давхар хариуцаж, бөөгийн үүргийг гүйцэтгэдэг байсан тул дээд тэнгэрээс ан авын хишиг гуйхдаа тэргүүндээ буга согооны эвэр залж, дээд тэнгэртэй холбогдох, хэл нэвтрэлцэх хэрэгсэл болгож байсан нь харагдаж байна.



Зураг 10. Өмнөговь аймгийн Ханбогд сум. Далайн дуулгын хадны зураг. Хүрэл, төмөр зэвсгийн үе

Зураг 11. Говь-Алтай аймгийн халиун сум. Цагаан голын хадны зураг. Хүрэл, төмөр зэвсгийн үе


Зураг 12. Хятад, ЮньНань муж. Да Май Дигийн хадны зураг. Хуучин чулуун зэвсгийн үе

Зураг 13. Хятад, Өвөр Монгол, Хө Лан Шан уулын хадны зураг. Хуучин чулуун зэвсгийн үе

Халх эхнэрийн үсний засал, толгойн гоёл дэлхийд хосгүй өвөрмөц хэлбэрээрээ алдартай. Үс гэзгээ ийнхүү өвөрмөц хэлбэрээр гоёж янзлахыг Монголчуудын уламжлалт аж ахуйн хэвшил, үхэр шүтлэгтэй холбон тайлбарлах нь элбэг. Ер нь үхэр шүтлэгийн ул мөр явсаар Хиндуизмын гурван гол бурханы нэг Шива бурхантай холбогдох ба тэр нь мөн Дравид соёлын гурван нүүрт, үхэр эвэртэй бурхнаас

уламжилсан гэдэг. Харин Буддын шашинд бол Оюун билгийн бурхан Манзушрийн догшин дүр, арван хангалын нэг Ямантаг бурхан нь үхэр дүртэй байдаг. Яма буюу эрлэгийг номхотгоод зуурдын оронд нас барагсдыг үнэн зөвөөр шүүн захирах эрх олсон тул ийнхүү алдаршжээ. Түүний хос эвэр нь хоёр үнэнийг ялгахын тухайтад бөгөөд агшин зур гурван ертөнцийг туулах чадалтай гэдэг.

Эртнээс нааш Дорнын ихэнх улс үндэстэн өндөр шовх оройтой малгай, эврийн хэлбэрээр гоёсон толгойн гоёл болон гэзэгний хэв маягийг таашаан хэрэглэж ирсэн байдаг. Судлаач МартаБояр Монгол эмэгтэйн толгойн гоёлыг судалсан зохиолдоо “Аль эрт РигВэдийн үед (НТӨ 1400 он) хүмүүс толгой дээрээ эвэр шиг босоо засал зүүдэг эмэгтэйчүүдийн тухай өгүүлсэн байдаг. Үүнээс гадна мөн цаг үед Индианы олон аймгуудын дунд эвэр хэлбэртэй гоёл дэлгэрч, байсан мэдээ бий. Тэдгээр эмэгтэйчүүдийн малгайн орой нь мушгиа эвэр хэлбэртэй байсан” (МартаБояр, 1994, 102-104) тухай өгүүлсэн байна. Энд өгүүлж буй эртний хүмүүсийн эвэрт толгойн гоёлын хожмын нэгэн илрэл нь Халх эхнэрийн үсний хэлбэр маяг, толгойн гоёл болно.



Зураг 15. Архангай аймаг. Суман голын хадны зураг. Хүрэл зэвсгийн үе
Зураг 16. Хятад, ЮньНань муж. Да Май Дигийн хадны зураг. Хүрэл зэвсгийн үе

Энэ мэт балар эртний хүмүүсийн буга, хандгай, зээр, үхэр зэрэг эвэрт амьтныг шидчилж, түүний тэнгэрлэг ид чадалд итгэх шүтлэг бишрэлийн зан үйлээс улбаалан уламжлагдаж ирсэн толгойн эвэр чимэглэл, эвэрт малгай нь үеэс үед утга агуулгаар баяжигдан, хэлбэр дүрсээ хувиргасаар ирсэн нь хүмүүсийн нийгэмд эзлэх байр суурь, хэргэм зэрэг, алба тушаал, эрх ямбыг илтгэх болж, Дорнын олон үндэстний хувцас засалд харилцан адилгүй дүр байдлаар илэрч, оюуны болон эдийн соёлд уламжлагдан иржээ.

ДҮГНЭЛТ

Балар эртний хүмүүсийн хүн-байгалийн нягт харилцаа, сансар ертөнцийн зохион байгуулалтыг шүтэн биширч, шууд ухааран тусгах космологийн сэтгэлгээнээс үндэстэй эвэр, эвэрт амьтныг тэнгэрийн ид чадалтай хэмээн ухамсарлах шүтлэгийн хэлбэр, түүнтэй холбогдох сүсэг бишрэлийн зан үйл нь эвэрт амьтны бэлгэдэл дүрийн өвөрмөц хэв маягийг хөгжүүлсээр иржээ.

Эвэрт амьтны дүр дүрслэл шүтлэг бишрэлийн гүн утга агуулгатай болох нь нэн эрт үед хамаарах хадан зургууд, буган чулуун хөшөө, оршуулгын эд зүйлс зэрэг археологийн олдворуудаар давхар батлагдаж байна.

Буга, согоо, хандгай, үхэр, зээр зэрэг эвэрт амьтныг овог аймгийнхаа сүлд, шүтээн болгож, түүний дүрийг тэргүүндээ залан дээд тэнгэрээс хүч чадал, ивээл хишиг хүртэхийн бэлгэдэл болгодог уламжлал Дорнын ард түмнүүдийн дунд нэлээд түгээмэл

дэлгэрсэн нь эвэр, эвэрт амьтны бэлгэдэл дүрийн ойлголт үеэс үед утга агуулгаар улам бүр баяжиж ирснийг харуулж байна.

Эвэрт амьтны бэлгэдэл тухайн үндэстний соёлын онцлогоос хамааран илрэх хэлбэр байдлын хувьд харилцан адилгүй ч, бэлгэдэл дүр, дүрслэл утга агуулгаараа ижил төстэй байгаа нь Дорнын үндэстнүүдийн оюуны соёлын нийтлэг уламжлалыг тусгасны илрэл болно.

РЕЗЮМЕ

В статье рассмотрены особенности изображения рогатых животных, их значение и символику, частовстречаемых в культуре и искусстве кочевых народов Востока, включая монголов в контексте концепции о структуре Вселенной и вероисповедания Небу. В связи с этим мы объяснили изображение, значение и символы рогатых животных с точки зрения вероисповедания. Сюда относятся и рогатый верблюд, единорогий антилоп, которые дошли до нас через скальные рисунки, оленные камни и предметы материальной культуры, устные народные творчества.

Вера в рогатых животных, владеющих сверхъестественной небесной силой, обогатилась вероисповеданием, передавалась через обычай и традиции поклонения, устные народные творчества оставила отпечаток в украшении одежды народов Востока.

НОМЗҮЙ

1. Батчулуун С. (2009). Монголын хадан зураг дахь дүр дүрслэлийг туульсын аман зохиолын дүрслэгээтэй холбон үзэхийн учир. – “Дүрслэх урлаг судлал 1”. МУБИС. ДУТэнхэм. Улаанбаатар: Алтан хэвлэл ХХК

2. Гантулга Ж., Ерөөл-Эрдэнэ Ч., Магай Ж. (2016). Хойд Тамирын буган хөшөө. ШУА. Түүх, археологийн хүрээлэн. Адмонпринт ХХК

3. Гомбрих Э. Х. (2010). Урлагийн түүх. Орчуулсан Баатар Ч. Nерко publishing. Бээжин

4. Гонгоржав Г. (2005). Монголчуудын чулуун өв соёл. Улаанбаатар: Адмонпринт ХХК

5. Дулам С. (1989). Монгол домог зүйн дүр. Улаанбаатар: Улсын хэвлэлийн үйлдвэр

6. Ерөөл-Эрдэнэ Ч. (2015). Хүннүгийн язгууртны оршуулгын дурсгалын судалгаа. ШУА. Түүх, археологийн хүрээлэн. Адмонпринт ХХК

7. МартаБояр. (1994). Монгол засал. Хөххот: Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо

8. 鄂小南, 苏日台. (2011). 使鹿部落民俗、艺术. 内蒙古文化出版社

Е Xiao Nan., Su Ri Tai. (2011). Цаатан овог аймгуудын ардын ёс заншил, урлаг. Өвөр Монголын хэвлэлийн хороо

9. 王立珍. (2006). 鄂温克族神话研究. 中央民族大学

Wang Li Zhen. (2006). Эвэнк үндэстний домог үлгэрийн судалгаа. Төвийн үндэстний Их Сургууль